



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/22

Улаанбаатар хот

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/122 дугаар захирамж, “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/122 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 3, 4, 5, 6, 7, 8, 11 дүгээр хороодод 2021 онд санхүүжүүлэх “Ахмад настан болон хүүхэд, залуучуудад зориулсан тоглоомын болон биеийн тамир, чийрэгжүүлэлтийн талбай” төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хороо (Б.Ганзориг)-нд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Х.Хонгорзул)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б. МӨНХБАТ

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 04 ны өдрийн дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.ГАНЗОРИГ

(Барилга захиалагчийн хэлтсийн дарга)

ГИШҮҮД:

Г.ТЭМҮҮЖИН

(НЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Эрчим хүчний (дулаан, цахилгаан) бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)

Б.САЙНБАЯР

(Захиргааны хэлтсийн Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн)

Г.ШООВДОР

(Баянгол дүүрэг 15 дугаар хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Х.ХОНГОРЗУЛ

(Барилга захиалагчийн хэлтсийн Барилгын хяналтын инженер)